

**АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ ТАЛБАЙГААС  
БИЧИЛ УУРХАЙГААР АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ ТУХАЙ  
ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭ**

2018 оны 9 сарын 10

№

Улаабаатар хот Налайх дүүрэг

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 5.3, 5.5 дахь заалтын дагуу нэг талаас Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг дарга Цаашид "Засаг дарга" гэхл *Ч. Раднаабазар* хоёрдогч талаас тус дүүргийн Зүүн хээр хэмээх газарт ашигт малтмал ашиглах *MV-012558* дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч Цаашид "компани" гэхл "Хэлтрэгэ" ХХК-ийн захирал Буянтогтох, гуравдагч талаас бичилуурхайн *Ор.А.* бүртгэгдээгүй нөхөрлөл Цаашид "нөхөрлөл" гэхл-ийн ахлагч *С. Дурэвдорж* бид нар харилцан тохиролцож энэхүү гурван талт гэрээ Цаашид "гэрээ" гэхл-г байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1.1 Компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайгаас нөхөрлөлд нүүрс олборлох зориулалтаар талбай ашиглуулахтай холбогдон Засаг дарга, Компани, Нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Энэхүү гэрээг 2018 оны 9 сарын 10 өдрөөс эхлэн 2019 сар, жилийн хугацаатайгаар байгуулав \ доогуур зурах\

**Хоёр. Компанийн хүлээх эрх, үүрэг**

2.1 Компани дараарх үүргийг хүлээнэ. Үүнд:

2.1.1 Өөрийн эзэмшиж буй уурхайн эдэлбэр газраас дор дурьдсан солбилцол бүхий цэгүүдийг холбосон шугамаар хүрээлэгдсэн ..... гектар талбайг нөхөрлөлд ашиглуулах:

№	Уртраг	Өргөрөг
1	<i>47° 44' 33.98"</i>	<i>107° 17' 27.75"</i>
2	<i>47° 44' 34.02"</i>	<i>107° 17' 29.28"</i>
3	<i>47° 44' 32.97"</i>	<i>107° 17' 29.17"</i>
4	<i>47° 44' 33.04"</i>	<i>107° 17' 27.48"</i>

2.1.2 Нөхөрлөлийг гэрээнд заасан солбицолын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавих,

2.1.3 Нөхөрлөл нь гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих,

2.1.4 Нөхөрлөл ашигт малтмал олборлох үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх,

2.1.5 Нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд саад учруулахгүй байх,

2.1.6 Ашигт малтмал олборлох явцад гэнэтийн осол гарсан тохиолдолд түүнийг арилгах, аврах ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх

**3.2 Засаг дарга нь дараах эрхтэй. Үүнд:**

- 3.2.1** Орон нутгийн эрх ашгийн үүднээс гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай санал тавих
- 3.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөхөрлөл болон компаниас шаардах
- 3.2.3 Хуулиар олгогдсон бусад эрх үүргээ хэрэгжүүлэх

### **Дөрөв. Нөхөрлөлийн үүрэг , эрх**

4.1 Нөхөрлөл дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 4.1.1** Энэхүү гэрээгээр олгогдсон талбайн хил хязгаарын дотор ашигт малтмал олборлох үйл ажиллагааг явуулах,
- 4.1.2** Гэрээгээр ашиглаж буй талбайн ашигт малтмалын нөөцийг бүрэн гүйцэт ашиглах
- 4.1.3** Компанийн үйл ажиллагаанд саад учруулахгүй байх,
- 4.1.4** Байгаль орчныг хамгаалах, голын ус, булаг шанд, уст цэгүүдийг зүй зохистой ашиглах,
- 4.1.5** Орчны тохижилтыг бололцоогоор хийх, хог хаягдлын цэгүүдийг байгуулах,
- 4.1.6 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дүрэм зааврыг хангаж ажиллах
- 4.1.7** Хууль ёсыг дээдэлж, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх

4.2 Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

- 4.2.1** Олгогдсон эдэлбэр газрын дотор олборлох үйл ажиллагаа явуулах,
- 4.2.2** Олгогдсон талбайгаас олборлосон бүтээгдэхүүнээ борлуулах,
- 4.2.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийг хийх болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулалтыг сайжруулахтай холбогдсон санал санаачилага гаргах,
- 4.2.4** Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг компани болон Засаг даргаас шаардах,

### **Тав. Бусад зүйл**

- 5.1 Гэрээнд оролцсон талууд харилцан хүндэтгэх зарчимд тулгуурлан хамтарч ажиллана.
- 5.2 Энэхүү гэрээнд тусгагдаагүй болог маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 5.3 Гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэнэ.
- 5.4 Гэрээнд оролцогч талуудын хэн нэгний буруу үйл ажиллагаанаас шалтгаалан бусад талуудын аль нэгэнд хохирол учирвал буруутай тал нь уг хохирлыг барагдуулах үүргийг хүлээнэ.
- 5.5 Гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд эс тохиролцвол шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 2.1.7 Засаг дарга болон нөхөрлөл хүсэлт тавьсан тохиолдолд мэргэжлийн болон бусад туслалцаа дэмжлэг үзүүлэх
- 2.1.8 Ашигт малтмал олборлосон **талбайн** нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд нөхөрлөлд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах,
- 2.1.9 Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг баяжуулах, **ангилах**, ялгах, цэг, талбайн байршлыг тогтоож өгөх,
- 2.1.10 Компани нь нөхөрлөлийн үйл ажиллагааны тухай мэдээллийг маягтын дагуу болон хавсралт зурганд тусган уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад уулын ажлын төлөвлөгөөг гэрээ байгуулсны дараа 1 сарын дотор тайланг хуулинд заасан хугацааны дотор хүргүүлэх,
- 2.1.11 Гэрээг цуцлах саналаа засаг дарга болон нөхөрлөлд бичгээр хүргүүлэх,

## 2.2 Компани нь дараах эрхтэй. Үүнд:

- 2.2.1 Компанийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулаагүй байхыг нөхөрлөлөөс шаардах: гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг засаг дарга болон нөхөрлөлд шаардах
- 2.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөхөрлөл болон засаг даргаас шаардах
- 2.2.3 Нөхөрлөлд нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, компанийн уурхайн хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай санал гаргах,
- 2.2.4 Нөхөрлөлийн гишүүдийн татвар, даатгалтай холбоотой асуудлыг хариуцахгүй байх,
- 2.2.5 Нөхөрлөлийн гэрээт талбайн үйл ажиллагаа явуулах болсон талаарх мэдээллийг төлөвлөгөө батлуулахдаа хавсралтаар гаргаж байх,

## **Гурав. Засаг даргын хүлээх эрх, үүрэг**

### 3.1 Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 3.1.1 Нөхөрлөлд олгож буй талбайн хил заагийг тогтоож шав тэмдэг тавих, ажлыг нөхөрлөл, компанитай хамтран гүйцэтгэх
- 3.1.2 Нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах
- 3.1.3 Нөхөрлөлийн гишүүдэд “Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм”-ийг тайлбарлан таниулах, ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд анхан шатны тусламж үзүүлэх, осол устгах талаар мэргэжлийн байгууллагаар сургалт хийлгэх ажлыг зохион байгуулах,
- 3.1.4 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд хяналт тавих
- 3.1.5 Хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу компани болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- 3.1.6 Нөхөрлөлийн гишүүдийн нийгмийн асуудлыг хувиараа ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах дүүргийн зөвлөлийн ажлын хүрээнд зохицуулах,
- 3.1.7 Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах,

5.6 Энэхүү гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:



5.6.1 Гэрээний хугацаа дууссан болон гэрээ сунгагдаагүй,

5.6.2 Гэрээг хугацаанаас өмнө цуцлах талаар аль нэг тал бусад талууддаа бичгээр мэдэгдсэн боловч бусад талууд ажлын таван өдөрт багтаан асуудлыг шийдвэрлээгүй тохиолдолд,

5.7 Гэрээ нь талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.8 Талууд харилцан тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бөгөөд нэмэлт, өөрчлөлт нь бичгээр хийгдэж талуудын гарын үсгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

**Гэрээ байгуулсан талууд:**



“Орд” нөхөрлөлийн  
.....  
РД.....